



## ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГЫН БОДЛОГО

### Нэг. Нийтлэг үндэслэл

- 1.1 Энэхүү баримт бичгийг Монгол Улсын Компанийн тухай хууль, Компанийн засаглалын кодексын хүрээнд нийцүүлэн боловсруулав.
- 1.2 Энэхүү бодлогын зорилго нь Бодь Даатгал ХК (цаашид “компани” гэх )-ийн стратеги, дунд болон богино хугацааны зорилго зорилтоо биелүүлэх явцад учрах эрсдлээс урьдчилан сэргийлэх, бууруулах, эрсдлээс үүдэн гарах алдагдлыг хамгийн бага түвшинд байлгах замаар эрсдэлийг удирдахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.
- 1.3 Төлөөлөн удирдах зөвлөл (цаашид ТҮЗ гэх) нь эрсдэлийн удирдлагын бодлогод нэмэлт, өөрчлөлт оруулах эрхтэй бөгөөд ТҮЗ-ын дэргэдэх Аудитын хороо нь байгууллагын эрсдэлийн удирдлага, түүний хэрэгжилтэнд хяналт тавина.

### Хоёр. Эрсдэл, түүний ангилал

- 2.1 Эрсдэл гэж компани зорилго, зорилтдоо хүрэхэд учрах тодорхой бус байдал, сөрөг нөлөө, үр дагавар, гарз хохирлыг ойлгоно.
- 2.2 Эрсдэлийн удирдлага гэдэг нь байгууллагын бүхий л ѿ шатанд эрсдэлийг тодорхойлох, үнэлэх, хариу арга хэмжээ авах, мэдээлэх тасралтгүй ажиллагаа юм.
- 2.3 Эрсдэлийг эх үүсвэрээс нь хамааруулан дараах байдлаар ангилж үзнэ.
  - 2.3.1 Стратегийн эрсдэл: Гадны болон дотоод хүчин зүйлсийн нөлөөллийн улмаас стратегийн зорилго, зорилт хангахад учрах эрсдэл
  - 2.3.2 Санхүүгийн эрсдэл: Гадны болон дотоод хүчин зүйлсийн нөлөөллөөс шалтгаалан, компанийн санхүүгийн үйл ажиллагаанд учрах эрсдэл
  - 2.3.3 Үйл ажиллагааны эрсдэл: Гадны болон дотоод хүчин зүйлсийн нөлөөллөөс шалтгаалан, компанийн үйл ажиллагаанд учрах эрсдэл
  - 2.3.4 Нийцлийн эрсдэл: Гадны болон дотоод хүчин зүйлсийн нөлөөллөөс шалтгаалан үл нийцэл үүсэх эрсдэл
- 2.4 Эрсдлийг үр дагавараас нь хамааруулан дараах ангиллаар тодорхойлон авч үзнэ.
  - 2.4.1 Стратегийн түвшний эрсдэл: Стратегийн зорилго, зорилтод нөлөөлөх үр дагавар бүхий эрсдэл
  - 2.4.2 Бизнес процессийн түвшний эрсдэл: Бизнесийн үйл ажиллагаанд нөлөөлөх үр дагавар бүхий эрсдлийг ойлгоно.
  - 2.4.3 Функционал нэгжүүд болон хувь хүний түвшний эрсдэл: Бүтцийн чиг үүрэг бүхий нэгжүүдэд болон хувь хүнд нөлөөлөх үр дагавар бүхий эрсдлийг ойлгоно.

### Гурав. Эрсдэлийн удирдлагын зарчим

Эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлэхэд дараах зарчмыг баримтлана.

- 3.1 Мэдээлэл ил тод байх.

- 3.1.1 Компанийн эрсдэлийн удирдлагын мэдээлэл солилцох ба зөвлөлдөх, хяналт ба мониторинг хийх үйл ажиллагаанд оролцох гадаад болон дотоод оролцогч талуудын хувь нэмрийг хүндэтгэн үзэх
  - 3.1.2 Эрсдэлийн удирдлага нь тодорхойгүй байдлыг ил болгох, системтэй цаг хугацаандаа, үнэн зөв мэдээлэл дээр суурилсан байх
- 3.2 Шийдвэр гаргалтанд ашиглагдах
  - 3.2.1 Эрсдэлийн удирдлага нь шийдвэр гаргалтын түвшин бүрт ашиглагддаг байх
- 3.3 Үнэ цэнийг бүтээх
  - 3.3.1 Эрсдэлийн удирдлага нь компанийд үнэ цэнийг нэмэгдүүлэх компанийн бүхий л үйл ажиллагааны салшгүй хэсэг байна.
- 3.4 Соёлыг түгээх
  - 3.4.1 Төлөөлөн удирдах зөвлөлийн зүгээс эрсдэлийн удирдлагын хүчирхэг соёлыг бий болгоход манлайлан оролцох
  - 3.4.2 Эрсдэлийн удирдлагын бодлого, заавар, журмууд нь компанийн өдөр тутмын үйл ажиллагаанд үйлчлэх ба компанийн удирдлага болон ажилчид дагаж мөрдөх
- 3.5 Тасралтгүй сайжруулан шинэчлэх
  - 3.5.1 Компани эрсдэлийн удирдлагын иж бүрэн тогтолцоог компанийн бүхий л түвшний үйл ажиллагаанд нэвтрүүлж, хэрэгжүүлж, олон улсын стандарт, сайн туршлагад үндэслэн тодорхой давтамжтайгаар тасралтгүй сайжруулах
  - 3.5.2 Компани нь стратеги зорилтууд, гадаад орчны өөрчлөлт, олон улсын практикт гарч буй эрсдэлийн удирдлагын шинэ мэдлэг, арга хандлагыг журам заавар, арга аргачлалдаа тусган байнга боловсронгуй болгон сайжруулж байх
- 3.6 Хэмжигдэхүйц байх
  - 3.6.1 Эрсдэлийг хэмжихдээ тоон болон нөлөөллийн шинжилгээний аргыг хослуулан ашиглах бөгөөд үр дүн хэмжигдэхүйц, удирдах боломжтой гэсэн зарчимд тулгуурлан тоон болон нөлөөллийн үнэлгээнд хөрвүүлэн ашиглах
- 3.7 Тайлагнадаг байх
  - 3.7.1 Бүх төрлийн эрсдэлийн тайланг тогтоосон загварын дагуу тогтмол давтамжтай, шуурхай гаргаж удирдлага, аудит болон эрсдэлийн хороо, Төлөөлөн удирдах зөвлөлд тайлагнадаг байх
- 3.8 Баримтжуулалт хийх
  - 3.8.1 Эрсдэлийг тодорхойлох, хэмжих, үнэлэх, хязгаар тогтоох, хяналт тавих, тайлагнах зэрэг эрсдэлийн удирдлагын бүх үйл ажиллагаа, түүнтэй холбогдох шийдвэрийг баримтжуулан баталгаажуулсан байна.
- 3.9 Чиг үүргийн хуваарилалт хийх
  - 3.9.1 Эрсдэлийн удирдлага, хяналтыг хэрэгжүүлэх алба, нэгжүүдийн үйл ажиллагаа, эрх үүргийн хуваарилалт оновчтой, тодорхой байх

#### **Дөрөв. Эрсдэлийн удирдлагын үйл явц**

- 4.1 Эрсдэлийн удирдлагын үйл явцад эрсдэл хариуцагчийн шийдвэр гаргах түвшинг зорилго, зорилтын эрэмбээр тогтоох ба Төлөөлөн удирдах зөвлөл, Эрсдэлийн хороо нь эрсдэлийн бодлого чиглэл тодорхойлогч байх бол гүйцэтгэх захирал, газрын захирал, хэлтсийн захирал, ахлах менежер, ажилчид эрсдэл хариуцагч байна.
- 4.2 Эрсдэлийн удирдлагын үйл явц нь төлөвлөлтийн бусад үйл явц, менежментийн үйл ажиллагаатай нягт уялдаатай байх
- 4.3 Эрсдэлийг тохиолдож болзошгүй үйл явдлын үр дагавар, түүний магадлалыг хослуулан авч үзнэ.

- 4.4 Эрсдэлийн удирдлагын тогтолцоо нь тулгарч болзошгүй эрсдэлийг тодорхойлох, тэдгээр эрсдлээс урьдчилан сэргийлэх, багасгаж болох арга хэмжээ авах, зайлшгүй тохиолдолд эрсдэлийг хүлээн зөвшөөрөх, шилжүүлэх, арилгах замаар хамгийн бага түвшинд байлгах арга хэмжээ авна.
- 4.5 Эрсдэлийн удирдлагын арга хэрэгслийг олон улсын стандарт, сайн туршилагад үндэслэн тасралтгүй сайжруулж байна.
- 4.6 Эрсдэлийн удирдлагын үйл явц дараах үе шаттайгаар хэрэгжинэ.
  - 4.6.1 Эрсдэлийг илрүүлэх, тодорхойлох
  - 4.6.2 Эрсдэлийг үнэлэх / шинжлэх, дүгнэх/
  - 4.6.3 Эрсдэлийг удирдах буюу хариу арга хэмжээ авах
  - 4.6.4 Хяналт мониторинг хийх
  - 4.6.5 Тайлاغнах

#### **Тав . Эрсдэлийн удирдлагын хэрэгжүүлэлт**

- 5.1 Эрсдэлийн удирдлагыг компанийн ТУЗ болон Гүйцэтгэх удирдлага хэрэгжүүлнэ.
- 5.2 Төлөөлөн удирдах зөвлөл нь дараах байдлаар эрсдэлийг удирдана.
  - 5.2.1 Эрсдэлийн удирдлагын бодлогыг тодорхойлох, батлах, түүнийг өөрчлөх
  - 5.2.2 Хүлээн зөвшөөрөх түвшнээс дээгүүр эрсдэлийн хязгаарыг батлах
  - 5.2.3 Стратегийн түвшний эрсдэлийг удирдах
  - 5.2.4 ТУЗ-ын дэргэдэх аудит, эрсдэлийн хороо, дотоод аудитын нэгжээр дамжуулан эрсдэлийн удирдлагын үйл ажиллагаа, түүний хэрэгжилт, үр ашигт хяналт тавих
- 5.3 Компанийн эрсдэлийн удирдлагыг хариуцан удирдах үндсэн бүтцийн нэгж нь эрсдэлийн удирдлагын баг байх ба уг багийн ахлахыг Гүйцэтгэх захирал томилно. Гүйцэтгэх захирал буюу түүний харьяа Эрсдэлийн нэгж нь дараах байдлаар эрсдэлийг удирдана.
  - 5.3.1 Төлөөлөн удирдах зөвлөлөөс баталсан эрсдэлийн удирдлагын бодлогын дагуу эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлэх
  - 5.3.2 Эрсдэлийг тодорхойлох, үнэлэх, хариу арга хэмжээ авах, тайлагнах талаарх журмыг батлах, хэрэгжүүлэх
  - 5.3.3 Эрсдлээс урьдчилан сэргийлэх, хохирлыг бууруулах ажлын төлөвлөгөө гаргаж ажиллах
  - 5.3.4 Эрсдэлийн хүлээн зөвшөөрөх түвшнээс дээгүүр эрсдэлийн хязгаарыг эрсдэлийн төрөл бүрээр тодорхойлж ТУЗ-аар батлуулах
  - 5.3.5 Жил бурийн эцэст эрсдэлийн удирдлагын бодлого, журмын хэрэгжилтэнд мониторинг хийж аудит эрсдэлийн хороонд тайлагнах
- 5.4 Эрсдэл хариуцсан шууд удирдлага
  - 5.4.1 Эрсдэлийн бодлогыг мөрдөж буй байдалд хяналт тавих, ТУЗ-д тайлагнах
  - 5.4.2 Эрсдэлийн бодлогын хүрээнд журам, арга аргачлалыг боловсруулах, хэрэгжилтийг хангуулах
  - 5.4.3 Эрсдэлийн удирдлагын журам, арга аргачлалыг дотоод аудитын зөвлөмж, олон улсын стандарт, сайн туршилагад үндэслэн тасралтгүй сайжруулж шинэчилж байх
  - 5.4.4 Эрсдэлийн бүртгэл хөтлөх, тайлагнах
  - 5.4.5 Эрсдэлийн нөлөөлөл, хохирол ул мөрийг арилгах арга хэмжээг шуурхай авч хэрэгжүүлэх
- 5.5 Эрсдэл хариуцагч ажилтai
  - 5.5.1 Эрсдэлийн бодлогыг хэрэгжүүлэх, үйл ажиллагааны журмын хэрэгжилтийг хангаж ажиллах
  - 5.5.2 Хэрэв эрсдэлийн холбогдох журам, хяналт нь хангалтгүй, эрсдэлийг даван туулахад үр дүнгүй байгаа тохиолдолд эрсдэлийн нэгжид мэдэгдэж холбогдох журам зохицуулалтын талаар санал оруулж шийдвэрлүүлэх
  - 5.5.3 Компанийн ажилтан бүр эрсдэлийн үр ашигтай менежмент хийхэд идэвхитэй оролцох

### **Зургаа. Хяналт сайжруулалт, өөрчлөлт оруулах**

- 6.1 Эрсдэлийн удирдлагын бодлого, түүний хэрэгжилтэнд ТУЗ-ын дэргэдэх аудит, эрсдэлийн хороо шууд болон дотоод аудитаад дамжуулан хяналт тавина.
- 6.2 Компанийн Төлөөлөн удирдах зөвлөл нь эрсдэлийн удирдлагын бодлогыг компанийн бизнес, үйл ажиллагааны өөрчлөлт болон зохицуулагч байгууллагын дүрэм, журам, олон улсын стандарт, сайн туршлагатай уялдуулан тодорхой давтамжтайгаар сайжруулан шинэчилж байна.